



БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хангал сумын Засаг даргын тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БУА-2023/46/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.open.audit.mn</p> <p>Булган аймаг 2023 он</p>	<p>Булган аймаг дахь төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудитор: Б.Эрдэнэ Утас: 7034-2580 Цахим хаяг: Erdeneb@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Ж.Энхцоодол Утас: 7034-2716 Цахим хаяг: enkhtsoodolj@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор: Д.Анхбаяр Утас: 7034-2495 Цахим хаяг: Ankhubayard@audit.gov.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	12
4. АУДИТЫН ТАЙЛАН	16
4.1 Ерөнхий зүйл.....	16
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	17
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	17
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
4.5.1 Завсрын аудитын талаар.....	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	18
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	18
5.1 Төлбөрийн акт	18
Төлбөрийн акт тогтоогдоогүй болно.....	18
5.2 Албан шаардлага	18
5.3 Зөвлөмж.....	19
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	19

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



БУЛГАН АЙМГИЙН ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Авхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082
Утас/Факс: 7034-2580
E-mail: bulgan@audit.gov.mn

2023.02.24 № 190

танай _____ ны № _____ т

ХАНГАЛ СУМЫН ЗДТГ-ЫН ДАРГА
Л.САЙНГЭРЭЛ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хангал сумын ЗДТГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хангал сумын ЗДТГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Аймгийн Засаг дарга сумын Засаг даргатай байгуулсан гэрээг дүгнүүлэн гүйцэтгэлийн үнэлгээгээр бусад сумдаа хошуучлан нэгдүгээр байр, хяналт шинжилгээ үнэлгээний дүнгээр гутгаар байр эзэлсэн ажилттай ажилласан байна.

Аудитын гол асуудал

Аймгийн ИТХ-ын IX/11 дугаар хуралдааны тогтоолыг үндэслэн сумын ЭМТ-өөс 9,075.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл, сумын Засаг даргын 2022 оны А/273 дугаар захирамжийг үндэслэн сумын ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 83,860.0 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 47,500.0 мянган

006020251

төгрөгийн бусад үндсэн хөрөнгийг шилжүүлэн авснаас шалтгаалан тайлант хугацааны үр дүнд нөлөөлж, засгийн газрын оролцоо данс өссөнөөс байна.

Бусад асуудлын хэсэг

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.ЭРДЭНЭ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	189,587,306.11	194,405,192.45
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	530,000.00	-
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	530,000.00	-
3121	Төгрөг	530,000.00	-
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах	530,000.00	-
33	АВЛАГА	1,591,500.00	-
335	Бусад авлага	1,591,500.00	-
3351	Байгууллагаас авах авлага	1,591,500.00	-
35	БАРАА МАТЕРИАЛ	187,465,806.11	194,405,192.45
354	Хангамжийн материал	177,229,806.11	184,673,192.45
35410	Бичиг хэргийн материал	4,548,849.00	5,247,240.00
35420	Аж ахуйн материал	31,084,246.06	31,301,809.40
35430	Сэлбэг хэрэгсэл	17,513,150.00	13,675,360.00
35440	Түлш, шатах тослох материал	452,100.00	209,700.00
35470	Бусад хангамжийн материал	123,631,461.05	134,239,083.05
35600	Мал амьтад	10,236,000.00	9,732,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,004,184,470.06	1,099,745,664.66
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,004,184,470.06	1,099,745,664.66
392	Биет хөрөнгө	998,179,369.94	1,094,292,264.42
39201	Барилга, байгууламж, орон сууц	900,066,176.44	900,066,176.44
39202	Хуримтлагдсан элэгдэл	(198,410,254.44)	(226,337,988.10)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	168,449,750.00	83,531,800.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(123,429,233.21)	(51,528,781.20)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	128,435,864.00	253,268,764.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(49,371,123.74)	(67,299,340.68)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	92,358,638.00	92,044,378.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(59,549,993.22)	(65,070,226.36)
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	90,000,000.00	90,000,000.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	64,476,773.15	111,976,773.15
39215	Хуримтлагдсан элэгдэл	(14,847,227.04)	(26,359,290.83)
393	Биет бус хөрөнгө	6,005,100.12	5,453,400.24
39301	Программ хангамж	2,256,800.00	2,256,800.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(551,699.88)	(1,103,399.76)
39303	Бусад биет бус хөрөнгө	4,300,000.00	4,300,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,193,771,776.17	1,294,150,857.11
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	1,121,750.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	1,121,750.00
413	Өглөг	-	1,121,750.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	1,121,750.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,193,771,776.17	1,293,029,107.11
51	Засгийн газрын хувь оролцоо	1,193,771,776.17	1,293,029,107.11
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	245,829,377.90	245,829,377.90
51101	Өмч:- төрийн	245,829,377.90	245,829,377.90
512	Хуримтлагдсан үр дүн	920,691,538.80	1,019,948,869.74
51210	Өмнөх үеийн үр дүн	920,691,538.80	920,691,538.80
51220	Тайлант үеийн үр дүн	-	99,257,330.94

51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	27,250,859.47	27,250,859.47
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,193,771,776.17	1,294,150,857.11

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/			
Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	600,029,470.25	891,467,595.69
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	87,463,885.00	143,770,668.00
120	Нийтлэг татварын бус орлого	87,463,885.00	143,770,668.00
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	87,463,885.00	143,770,668.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	556,500.00	466,500.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	86,907,385.00	143,304,168.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	512,565,585.25	747,696,927.69
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	70,498,362.00	189,286,722.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	8,941,000.00	1,591,500.00
131103	ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	16,000,000.00	20,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,302,562.00	160,935,008.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	41,254,800.00	6,760,214.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	442,067,223.25	558,410,205.69
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	409,665,723.25	558,410,205.69
132004	Оны эхний үлдэгдлээс санхүүжих / орон нутгийн төсөв/	32,401,500.00	-
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	521,672,776.38	781,960,329.06
21	УРСГАЛ ЗАРДАЛ	521,672,776.38	617,042,266.06
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	520,750,560.13	580,201,887.60
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	210,392,969.00	245,044,511.74
210101	Үндсэн цалин	146,680,621.00	180,297,766.52
210102	Нэмэгдэл	59,762,557.00	46,700,222.66
210104	Урамшуулал	-	17,745,954.56
210105	Гэрээт ажлын хөлс	3,949,791.00	300,568.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	27,318,960.81	31,011,961.01
210201	Тэтгэврийн даатгал	19,033,028.69	21,402,350.95
210202	Тэтгэмжийн даатгал	2,115,378.79	2,406,438.70
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,692,303.12	1,925,735.05
210204	Ажилгүйдлийн даатгал	422,233.57	478,498.63
210205	Эрүүл мэндийн даатгал	4,056,016.64	4,798,937.68
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	122,510,768.60	122,603,180.48
210301	Гэрэл, цахилгаан	3,274,821.60	5,952,533.48
210302	Түлш, халаалт	117,095,947.00	116,650,647.00
210303	Цэвэр, бохир ус	2,140,000.00	-
2104	Хангамж, бараа материалын зардал	16,264,190.00	25,987,373.00

210401	Бичиг хэрэг	1,640,465.00	2,561,225.00
210402	Тээвэр, шатахуун	11,965,635.00	20,635,748.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,389,340.00	1,227,400.00
210404	Ном, хэвлэл	94,400.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	774,850.00	1,396,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	399,500.00	166,500.00
2105	Нормативт зардал	178,400.00	468,801.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	178,400.00	468,801.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	732,600.00	8,645,100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	30,000.00	-
210604	Урсгал засвар	702,600.00	8,645,100.00
2107	Томилолт, зочны зардал	1,861,000.00	6,508,000.00
210702	Дотоод албан томилолт	1,861,000.00	6,508,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,824,009.00	872,109.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	320,030.00	334,700.00
210803	Даатгалын үйлчилгээ	888,000.00	128,100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	361,979.00	310,309.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	154,000.00	99,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,100,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	137,667,662.72	139,060,851.37
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	51,196,482.40	50,612,498.66
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	164,000.00	1,151,500.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	86,307,180.32	87,296,852.71
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	922,216.25	36,840,378.46
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	33,092,600.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	-	11,653,300.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	20,939,300.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	500,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	922,216.25	3,747,778.46
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	922,216.25	3,747,778.46
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	164,918,063.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	164,918,063.00
220001	Барилга байгууламж	-	43,306,597.00
223001	Бусад хөрөнгө	-	121,611,466.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	78,356,693.87	109,507,266.63
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	6,450,000.00	5,772,000.00
145002	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз	6,450,000.00	5,772,000.00
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	48,308,851.74	16,021,935.69
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	46,926,666.74	15,758,535.69
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	1,382,185.00	263,400.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(41,858,851.74)	(10,249,935.69)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	36,497,842.13	99,257,330.94

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/			
Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он

1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	513,122,085.25	748,163,427.69
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	556,500.00	466,500.00
120	Нийтлэг татварын бус орлого	556,500.00	466,500.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	556,500.00	466,500.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	556,500.00	466,500.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	512,565,585.25	747,696,927.69
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	70,498,362.00	189,286,722.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	8,941,000.00	1,591,500.00
131103	ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	16,000,000.00	20,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,302,562.00	160,935,008.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	41,254,800.00	6,760,214.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	442,067,223.25	558,410,205.69
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	409,665,723.25	558,410,205.69
132004	Оны эхний үлдэгдлээс санхүүжих / орон нутгийн төсөв/	32,401,500.00	-
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	459,225,186.25	537,133,964.69
21	УРСГАЛ ЗАРДАЛ	459,225,186.25	537,133,964.69
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	456,711,470.00	500,293,586.23
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	210,392,969.00	245,044,511.74
210101	Үндсэн цалин	146,680,621.00	180,297,766.52
210102	Нэмэгдэл	59,762,557.00	46,700,222.66
210104	Урамшуулал	-	17,745,954.56
210105	Гэрээт ажлын хөлс	3,949,791.00	300,568.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	27,279,749.34	31,011,961.01
210201	Тэтгэврийн даатгал	18,993,817.22	21,402,350.95
210202	Тэтгэмжийн даатгал	2,115,378.79	2,406,438.70
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,692,303.12	1,925,735.05
210204	Ажилгүйдлийн даатгал	422,233.57	478,498.63
210205	Эрүүл мэндийн даатгал	4,056,016.64	4,798,937.68
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	122,802,754.66	122,603,180.48
210301	Гэрэл, цахилгаан	2,992,607.66	5,952,533.48
210302	Түлш, халаалт	116,900,147.00	116,650,647.00
210303	Цэвэр, бохир ус	2,910,000.00	-
2104	Хангамж, бараа материалын зардал	18,528,126.00	25,060,380.00
210401	Бичиг хэрэг	1,879,800.00	1,920,300.00
210402	Тээвэр, шатахуун	9,586,605.00	16,518,980.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,704,120.00	1,381,400.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	4,832,101.00	2,016,100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	525,500.00	3,223,600.00
2105	Нормативт зардал	2,124,200.00	456,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,124,200.00	456,000.00

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,909,100.00	14,857,950.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	577,100.00	1,358,000.00
210604	Урсгал засвар	10,332,000.00	13,499,950.00
2107	Томилолт, зочны зардал	1,861,000.00	6,508,000.00
210702	Дотоод албан томилолт	1,861,000.00	6,508,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,789,659.00	872,109.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	285,680.00	334,700.00
210803	Даатгалын үйлчилгээ	888,000.00	128,100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	361,979.00	310,309.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	154,000.00	99,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,100,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	59,023,912.00	53,879,494.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	58,331,912.00	51,912,144.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	692,000.00	1,967,350.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,513,716.25	36,840,378.46
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	33,092,600.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	-	11,653,300.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	20,939,300.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	500,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	2,513,716.25	3,747,778.46
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,513,716.25	3,747,778.46
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	53,896,899.00	211,029,463.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	53,366,899.00	211,559,463.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	53,366,899.00	211,559,463.00
2200	Дотоод эх үүсвэрээр	53,366,899.00	211,559,463.00
220001	Барилга байгууламж	-	43,306,597.00
222001	Тоног төхөөрөмж	3,517,899.00	44,677,400.00
223001	Бусад хөрөнгө	49,849,000.00	123,575,466.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(53,366,899.00)	(211,559,463.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	530,000.00	(530,000.00)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	530,000.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	530,000.00	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/Төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	245,829,377.90	27,250,859.47	920,691,538.80	1,193,771,776.17
2	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	245,829,377.90	27,250,859.47	920,691,538.80	1,193,771,776.17

3	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	245,829,377.90	27,250,859.47	920,691,538.80	1,193,771,776.17
4	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	245,829,377.90	27,250,859.47	920,691,538.80	1,193,771,776.17
5	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	245,829,377.90	27,250,859.47	920,691,538.80	1,193,771,776.17
6	Тайлант үеийн үр дүн	-	-	99,257,330.94	99,257,330.94
7	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	245,829,377.90	27,250,859.47	1,019,948,869.74	1,293,029,107.11

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	558,730,900.0	558,876,705.7	(145,805.69)	100.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	558,730,900.0	513,435,305.7	45,295,594.31	91.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	525,638,300.0	476,594,927.2	49,043,372.77	90.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	245,416,900.0	245,044,511.7	372,388.26	99.8
210101	Үндсэн цалин	174,295,200.0	180,297,766.5	(6,002,566.52)	103.4
210102	Нэмэгдэл	39,281,200.0	46,700,222.7	(7,419,022.66)	118.9
210105	Гэрээт ажлын хөлс	31,840,500.0	300,568.0	31,539,932.00	0.9
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	30,119,900.0	31,011,961.0	(892,061.01)	103.0
210201	Тэтгэврийн даатгал	20,481,500.0	21,402,351.0	(920,850.95)	104.5
210202	Тэтгэмжийн даатгал	1,991,300.0	2,406,438.7	(415,138.70)	120.8
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,346,000.0	1,925,735.1	420,264.95	82.1
210204	Ажилгүйдлийн даатгал	481,900.0	478,498.6	3,401.37	99.3
210205	Эрүүл мэндийн даатгал	4,819,200.0	4,798,937.7	20,262.32	99.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	123,451,300.0	119,945,466.5	3,505,833.52	97.2
210301	Гэрэл, цахилгаан	6,800,600.0	3,294,819.5	3,505,780.52	48.4
210302	Түлш, халаалт	116,650,700.0	116,650,647.0	53.00	100.0
2104	Хангамж, бараа материалын зардал	21,305,500.0	22,400,300.0	(1,094,800.00)	105.1
210401	Бичиг хэрэг	1,919,800.0	1,920,300.0	(500.00)	100.0
210402	Тээвэр, шатахуун	13,178,900.0	14,178,900.0	(1,000,000.00)	107.6
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,706,800.0	1,381,400.0	325,400.00	80.9
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,000,000.0	1,696,100.0	1,303,900.00	56.5
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,500,000.0	3,223,600.0	(1,723,600.00)	214.9
2105	Нормативт зардал	3,300,000.0	456,000.0	2,844,000.00	13.8
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,300,000.0	456,000.0	2,844,000.00	13.8
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	58,000,000.0	10,155,450.0	47,844,550.00	17.5
210601	Багаж, техник, хэрэгсэл	50,000,000.0	1,358,000.0	48,642,000.00	2.7
210604	Урсгал засвар	8,000,000.0	8,797,450.0	(797,450.00)	110.0
2107	Томилолт, зочны зардал	4,656,000.0	6,508,000.0	(1,852,000.00)	139.8
210702	Дотоод албан томилолт	4,656,000.0	6,508,000.0	(1,852,000.00)	139.8

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,038,700.0	872,109.0	166,591.00	84.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	500,000.0	334,700.0	165,300.00	66.9
210803	Даатгалын үйлчилгээ	300,000.0	128,100.0	171,900.00	42.7
210804	Тээврийн хэрэгслийн татвар	128,700.0	310,309.0	(181,609.00)	241.1
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	110,000.0	99,000.0	11,000.00	90.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	38,350,000.0	40,201,129.0	(1,851,129.00)	104.8
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	37,000,000.0	39,205,279.0	(2,205,279.00)	106.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,350,000.0	995,850.0	354,150.00	73.8
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	33,092,600.0	36,840,378.5	(3,747,778.46)	111.3
2132	Бусад урсгал шилжүүлэг	33,092,600.0	33,092,600.0	-	100.0
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	11,653,300.0	11,653,300.0	-	100.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	20,939,300.0	20,939,300.0	-	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	500,000.0	500,000.0	-	100.0
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлэн захирагчдад олгох	-	3,747,778.5	(3,747,778.46)	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	3,747,778.5	(3,747,778.46)	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		45,441,400.0	(45,441,400.0)	-
	Дотоод эх үүсвэрээр		45,441,400.0	(45,441,400.0)	-
222001	Тоног төхөөрөмж		44,677,400.0	(44,677,400.0)	-
223001	Бусад хөрөнгө		764,000.0	(764,000.00)	-
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	558,810,205.7	558,876,705.7	(66,500.00)	100.0
132	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	558,410,205.7	558,410,205.7	-	100.0
132001	Орон нутгийн төсвөөс	558,410,205.7	558,410,205.7	-	100.0
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	400,000.0	466,500.0	(66,500.00)	116.6
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл			-	-
1	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	100.0
2	АЖИЛЛАГСАДЫН ТОО	23	22	1	95.7
3	Удирдах ажилтан	5	5	-	100.0
4	Гүйцэтгэх ажилтан	13	12	1	92.3
5	Үйлчлэх ажилтан	4	4	-	100.0
6	Гэрээт ажилтан	1	1	-	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/Төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	189,816,722.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	22,498,659.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	22,498,659.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	2,657,714.00

210301	Гэрэл, цахилгаан	2,657,714.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2,660,080.00
210402	Тээвэр, шатахуун	2,340,080.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	320,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,702,500.00
210604	Урсгал засвар	4,702,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	12,478,365.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	11,506,865.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	971,500.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	167,318,063.00
2200	Дотоод эх үүсвэрээр	167,318,063.00
220001	Барилга байгууламж	43,306,597.00
223001	Бусад хөрөнгө	124,011,466.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	189,286,722.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	189,286,722.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	1,591,500.00
131103	ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	20,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	160,935,008.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	6,760,214.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	530,000.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Хангал сумын Засаг даргын тамгын газар эрхэм зорилгоо “МУ-ын ЗГ-ын болон аймаг сумын Засаг даргын мөрийн хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, орон нутгийн хөгжилд дэмжлэг үзүүлэх” гэж тодорхойлжээ. 2022 онд “Эрч хүчтэй, бүтээлч сэтгэлгээтэй шинийг эрэлхийлсэн, чадварлаг эвсэг хам олон хөгжлийн хөтөч уриатай мэдлэг чадварт суурилсан, мэргэшсэн захиргааны байгууллага болох” зорилтыг дэвшүүлэн, үйл ажиллагааны чиглэлээ дараа байдлаар тодорхойлжээ.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаандаа Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Хөдөлмөрийн тухай, Төрийн хэмнэлтийн тухай, шилэн дансны тухай, Татварын багц, Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон түүнийг дагалдаж гарсан тогтоол, дүрэм журам, эрх бүхий албан тушаалтнуудын шийдвэрүүдийн хэрэгжилтийг ханган үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын

сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хангал сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Хангал сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Аймгийн Засаг даргын 2020 оны А/424 дугаар захирамжаар баталсан бодлогын баримт бичгийг үйл ажиллагаандаа ашиглаж байна. 2022 онд бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 100,379.1 мянган төгрөгөөр буюу 8.4 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	530.00	-	(530.00)
Авлага	1,591.50	-	(1,591.50)
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	187,465.81	194,405.19	6,939.39
Үндсэн хөрөнгө	1,004,184.47	1,099,745.66	95,561.19
Нийт хөрөнгө	1,193,771.78	1,294,150.86	100,379.08
Өр төлбөр	-	1,121.75	1,121.75
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,193,771.78	1,293,029.11	99,257.33

Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,193,771.78	1,294,150.86	100,379.08
---	---------------------	---------------------	-------------------

Дээрх хүснэгтээс харахад тайлант онд материаллаг өөрчлөлт гарсан данс нь үндсэн хөрөнгө, үндсэн хөрөнгийн оролцоо данснууд өссөн байна.

Аймгийн ИТХ-ын IX/11 дугаар хуралдааны тогтоолоор сумын ЭМТ-өөс 9,075.0 мянган төгрөгийн пургон авто машиныг шилжүүлэн авсан, сумын Засаг даргын 2022 оны А/273 дугаар захирамжийг үндэслэн сумын ОНХС-гийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 83,860.0 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 47,500.0 мянган төгрөгийн кантинар, зам гүүрийн байгууламжийг орлогод авч тайлагнаснаас шалтгаалан тайлант хугацааны үр дүн нэмэгдэж, засгийн газрын оролцоо данс өссөнөөс байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 465,692.5 мянга, өөрийн орлогоос 400.0 мянган төгрөг нийт 466,092.4 мянган төгрөгийг бүрдүүлэхээр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаар зардлыг 465,692.5 мянган төгрөгөөр, өөрийн орлогоос 400.0 мянган төгрөг нийт 466,092.5 мянган төгрөгөөр баталсан байна. Тайлант онд 1 удаа тодотгол хийгдэж, тоног төхөөрөмж 40,000.0 мянга, урсгал засвар 5,000.0 мянга, шатахууны зардал 4,000.0 мянга, цалингийн зардал 27,383.5 мянга, НДШ-ийн зардал 9,655.0 мянга, багаж техникийн зардал 7,000.0 мянган төгрөг нийт 93,038.5 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 8 арга хэмжээг санхүүжүүлэхээр орон нутгийн ерөнхий орлогоос эхний үлдэгдэл 24,457.0 мянга, өөрийн орлого 400.0 мянга, орон нутгийн төсвөөс 513,874.0 мянган төгрөг нийт 558,730.9 мянган төгрөгийг бүрдүүлэхээр байна. Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 558,410.2 мянган төгрөгийн санхүүжилт авч, 466.5 мянган төгрөгийн өөрийн орлогыг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 555,128.9 мянган төгрөг буюу 99.4 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 3,602.4 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган

төгрөгөөр/

Д/ Д	Хөтөлбөр арга хэмжээний		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэл т
	Код	Хөтөлбөр арга хэмжээ				
Нийт дүн			558,730.9	555,128.5	3,602.4	99.4
1	7010 6	80101	411,313.5	408,039.5	3,274.0	99.2
2		80106	58,343.0	58,083.3	259.7	99.6
3		80112	19,281.9	19,281.8	0.1	100.0
4		80802	21,439.3	21,439.3	-	100.0
5		80815	11,653.3	11,653.3	-	100.0
6		81102	30,000.0	29,935.3	64.7	99.8
7		82212	1,700.0	1,696.1	3.9	99.8
8		82801	5,000.5	5,000.0	-	100.0

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд 189,286.7 мянган төгрөгийн нэмэлт санхүүжилт авч эдийн засгийн ангиллын дагуу зарцуулалтын эрх нээлгэн зарцуулсан байна. Нэмэлт орлогын эх үүсвэрийг хүснэгтээр харуулав.

№	Эх үүсвэр	Мөнгөн дүн
1	Шүлхийн шатахууны зардлаас нэмэлт санхүүжилтийн төвлөрүүлснийг буцаан төлөгдсөн авлага	1,591.5
2	Аймгийн авто замын сангаас ургацын зам засварт	20,000.0
3	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаас эрх шилжүүлж шинэ суурьшлын бүсийн цахилгаан дамжуулах агаарын шугам барих ажилд	144,743.4
4	Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас морин эргүүлийн урамшуулалд	1,666.0
5	Сумын орон нутгийн хөгжлийн сангаас баяр наадмын зардалд	5,000.0
6	Статистикийн хэлтсээс хөдөө аж ахуйн болон хагас жилийн мал тооллого, багийн засаг дарга нарт тооллогын урамшуулалд	1,985.6
7	Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас цэвэр орчин цэмцгэр булган аяны зардалд	1,500.0
8	Аймгийн байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас байгалийн гамшгийн эрсдэлийг бууруулах арга хэмжээний зардалд	5,000.0
9	Усны орлого, усны картын орлого	3,987.7
10	Туслах аж ахуйн орлого /малын ашиг шим/	660.0

11	Түрээсийн орлого	200.0
12	нийгмийн хариуцлагын гэрээнд компаниудаас бэлчээрийн хог хаягдлын төлбөр, ахмадын байрны засварт	2,952.5
Нийт дүн		189,286. 7

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хангал сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Булган аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Д.Анхбаяр гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Ж.Энхцоодол, дарга, тэргүүлэх аудитор Б.Эрдэнэ нар тус тус хэрэгжүүлсэн.

Хангал сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 03/34 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны батлагдсан төсвөөс 558,731.0 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 8,380.9 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 6,285.7 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тухайн байгууллага 12 дугаар зүйлийн 12.1.1, 12.1.2, 12.1.3 дахь заалтууд, 15 дугаар зүйлийн 15.1.2-15.1.7 дахь заалтуудад заасан хуулиар хориглосон зардлуудыг санхүүжүүлээгүй байна.

Хуулийн 15 дугаар зүйлд заасан хэмнэлтийн бусад арга хэмжээтэй холбоотой зардлуудыг санхүүжүүлээгүй байна. Хуулийн 20 дугаар зүйлийн тайлагнал, ил тод байдлын 20.5 -д заасан этгээд шилэн дансны тухай хуульд заасан 5 мэдээллийг хугацаа хоцруулж байршуулсан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Шилэн дансны тухай хуульд заасан нийт 152 мэдээлэл мэдээлэхээс 11 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн 5 мэдээллийг мэдээлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Тайлант хугацаанд завсрын аудит хийгдээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар тогтоосон зөвлөмжийн хэрэгжилтийг 2022 оны 09 дүгээр сарын 06-ны өдрийн 03/268 дугаар албан тоотоор ирүүлсэн.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	2	190,750.5	2	190,750.5	2

/мянган төгрөгөөр/

Зөвлөмж	3	-	3	-	3
Нийт дүн	5	190,750.5	5	190,750.5	5

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Аудитын гүйцэтгэх цаг хугацааны нөөц, цар хүрээ хязгаарлагдмал байсан учраас дараагийн санхүүгийн тайлангийн аудитаар бараа материал, үндсэн хөрөнгийн үлдэгдэлд бүрэн тооллогын горим сорил хэрэгжүүлэн, өмч хамгаалах зөвлөлийн үйл ажиллагааны тайлан, 2022 оны жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогын тайланд дурдсан зүйлсийг шийдвэрлэсэн байдал зэргийг тусгайлан авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 14,123.6 мянган төгрөгийн зөрчил¹ илэрснээс, 797.2 мянган төгрөгийн 2 албан шаардлага хүргүүлж, 13,325.9 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогдоогүй болно.

5.2 Албан шаардлага

1. Аймгийн Засаг даргын 2022 оны А/354 дугаар захирамжаар нягтлан бодогчид 1 сарын үндсэн цалинтай тэнцэх урамшууллыг давхардуулан олгосон байна.

Энэ нь Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журмын 1.2.2 “*төсвийн шууд захирагч нь байгууллагын төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн үнэлгээ, улирлын ажлын үр дүнг үндэслэн холбогдох гүйцэтгэлийн үнэлгээний журамд тодорхойлсон мөнгөн урамшуулал авах нөхцөлийг хангасан төрийн албан хаагчид*”-д заасантай нийцээгүй, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хууль тогтоомжийг хэрэгжүүлэн батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, алдаа зөрчлийг таслан зогсоох албан шаардлага өгөх.

2. Тайлант хугацаанд Шилэн дансны тухай хуульд заасан нийт 152 мэдээлэл мэдээлэхээс 11 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн 5 мэдээллийг мэдээлээгүй байна.

Энэ нь шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1, 4.1.3 дэх заалт, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 дахь заалттай нийцээгүй, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуул болон Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах, алдаа зөрчлийг таслан зогсоох албан шаардлага өгөх.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Цалингийн зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Илүү цагийн нэмэгдлийг 12 дугаар сард 4 албан хаагчдад 3.2 цагаар хэтрүүлэн олгосон байна.

Энэ нь Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчдад нэмэгдэл хөлс олгох журмын 3.3-д *“Илүү цагаар, долоо хоногийн амралтын өдрөөр, нийтээр амрах баяр ёслолын өдрөөр, шөнийн цагаар ажилласны нэмэгдэл хөлс тооцох цаг нь 4.1-т зааснаас бусад тохиолдолд тухайн сарын ажлын цагийн 10 хувиас хэтрэхгүй байна. Тухайлбал, 8 дугаар сарын ажлын цаг 160 гэж үзвэл тухайн сард нэмэгдэл хөлс тооцогдох цаг нь 16-аас илүүгүй байна”* гэж заасантай нийцээгүй, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журам”-ын 3.3 дахь заалтыг мөрдөж ажиллах

2. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Өмч хамгаалах байнгын зөвлөлийн шийдвэргүй, хөрөнгийн ерөнхий болон техникийн байдлыг хөрөнгө нэг бүрээр нь газар дээр нь шалгуулж, дүгнэлт гаргуулаагүй эд хөрөнгийг акталж данснаас хассан байна.

Энэ нь ТӨБЗГ-ын 2018 оны 86 дугаар тогтоолоор баталсан Өмч хамгаалах байнгын зөвлөлийн үйл ажиллагааны нийтлэг журмыг хэрэгжүүлээгүй, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Өмч хамгаалах зөвлөлийн үйл ажиллагааны нийтлэг журмыг мөрдөж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 06 дугаар сарын 10 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
Аймгийн Засаг даргын 2022 оны А/354 дугаар захирамжаар нягтлан бодогчид 1 сарын үндсэн цалинтай тэнцэх урамшууллыг давхардуулан олгосон байна.	1	797.6	-	-	1	797.6	-	-	-	-	-	-
Илүү цагийн нэмэгдлийг 12 дугаар сард 4 албан хаагчдад 3.2 цагаар хэтрүүлэн олгосон байна.	1	-	-	-	-	-	1	648.6	-	-	-	-
Өмч хамгаалах байнгын зөвлөлийн шийдвэргүй, хөрөнгийн ерөнхий болон техникийн байдлыг хөрөнгө нэг бүрээр нь газар дээр нь шалгуулж, дүгнэлт гаргуулаагүй эд хөрөнгийг акталж данснаас хассан байна.	1	13,325.9	-	-	-	-	1	13,325.9	-	-	-	-
Дүн	3	14,123.5	-	-	1	797.6	2	13,974.5	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Байхгүй.								
Тайлант хугацаанд Шилэн дансны тухай хуульд заасан нийт 152 мэдээлэл мэдээлэхээс 11 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн 5 мэдээллийг мэдээлээгүй байна.	1	-	-	-	1	-	-	-
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Байхгүй.								
Дүн								
Нийт дүн								